



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний
бүртгэлийн санд өөрчлөлт оруулах
журмыг шинэчлэн батлах тухай

Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан тус газрын “Дүрэм”-ийн 2.5.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд өөрчлөлт оруулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд байнгын хяналт тавьж, энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баяр/-т, Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн зөвлөмж удирдлагаар хангаж ажиллахыг орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Доржпалам/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд өөрчлөлт оруулах журам батлах тухай” Нийслэлийн Тээврийн газрын даргын 2015 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн А/35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.ОТГОНБААТАР



